**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/07/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг:uuriintuya.b@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....12
3. Аудитын тайлан....14
3.1 Ерөнхий зүйл....14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....15
3.4 Материаллаг байдал ....15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....18
3.8 Аудитын гол асуудал ....18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....19
4. Аудитын илрүүлэлт ....19
4.1 Залруулсан алдаа.... 19
4.2 Төлбөрийн акт.... 19
Байхгүй .... 19
4.3 Албан шаардлага .... 19
4.4 Зөвлөмж .... 19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Т.НАЗЫМ ТАНАА

2022.02.11 № 34
танай ______ -ны № ______ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

ОНӨГ-Дүгнэлт-2.08-ТА

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

ОНӨГ-Дүгнэлт-2.08-ТА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,448,927.10** | **1,598,500.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| 31140 | Касс арилжааны банк | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | 808,427.10 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 808,427.10 | |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **640,500.00** | **1,598,500.00** |
| **354** | **Хангамжийн материал** | 640,500.00 | 1,598,500.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | - |
| 35420 | Аж ахуйн материал | 640,500.00 | 640,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **14,658,326.61** | **1,874,439,579.85** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 14,658,326.61 | 1,874,439,579.85 |
| **392** | **Биет хөрөнгө** | 13,458,326.61 | 1,846,839,579.85 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | - | 1,831,500,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | - | - |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 22,967,671.00 | 20,007,604.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (14,780,570.90) | (9,153,437.19) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,982,697.00 | 12,488,104.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,711,470.49) | (8,002,690.96) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | - |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,200,000.00 | 27,600,000.00 |
| 39301 | Програм хангамж | - | - |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,200,000.00 | 27,600,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **16,107,253.71** | **1,876,038,079.85** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - |
| **4136** | **Бусад өглөг** | - | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **16,107,253.71** | **1,876,038,079.85** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 16,107,253.71 | 1,876,038,079.85 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 45,657,976.00 | 72,057,976.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 45,657,976.00 | 72,057,976.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (37,128,122.29) | 1,801,180,499.85 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (40,016,962.89) | (32,350,326.29) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,888,840.60 | 1,833,530,826.14 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,577,400.00 | 2,799,604.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **16,107,253.71** | **1,876,038,079.85** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **197,134,931.00** | **2,033,473,129.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **38,912,400.00** | **60,912,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 38,912,400.00 | 60,912,200.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 38,912,400.00 | 60,912,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 38,912,400.00 | 60,912,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **158,222,531.00** | **1,972,560,929.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,944,500.00 | 11,807,229.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,944,500.00 | 11,807,229.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 142,278,031.00 | 1,960,753,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 142,278,031.00 | 129,253,700.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 1,831,500,000.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **194,246,090.40** | **199,942,302.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **194,246,090.40** | **199,942,302.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 178,488,159.40 | 198,145,025.86 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 129,811,113.90 | 156,393,750.10 |
| 210101 | Үндсэн цалин | 129,811,113.90 | 133,375,858.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | - | 20,268,651.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 2,749,241.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,365,762.00 | 10,433,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,365,762.00 | 10,433,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | - |
| 210302 | Түлш, халаалт | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,457,797.00 | 14,143,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,582,961.00 | 5,507,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,729,300.00 | 6,746,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,145,536.00 | 1,585,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 303,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 710,000.00 | 1,806,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| 210604 | Урсгал засвар | 710,000.00 | 1,806,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 2,695,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 2,695,300.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,006,900.00** | **2,683,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 675,600.00 | 716,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 333,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,691,300.00 | 1,433,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,136,586.50** | **9,989,575.76** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,641,000.00 | 4,965,422.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,495,586.50 | 4,024,153.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,757,931.00** | **1,797,277.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,174,231.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 6,174,231.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,583,700.00 | 1,797,277.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,583,700.00 | 1,797,277.00 |
| 213404 | Хөрөнгийн | - | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |
| 220001 | Барилга байгууламж | - | - |
| 223001 | Бусад хөрөнгө | - | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,888,840.60** | **1,833,530,826.14** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | - | - |
| 145003 | Хөрөнгө оруулалтын олз | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| 225002 | Найдваргүй авлагын алдагдал | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,888,840.60** | **1,833,530,826.14** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 45,657,976.00 | 7,577,400.00 | (37,128,122.29) | 16,107,253.71 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **45,657,976.00** | **7,577,400.00** | **(37,128,122.29)** | **16,107,253.71** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **45,657,976.00** | **7,577,400.00** | **(37,128,122.29)** | **16,107,253.71** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **45,657,976.00** | **7,577,400.00** | **(37,128,122.29)** | **16,107,253.71** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 4,777,796.00 | 4,777,796.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **45,657,976.00** | **7,577,400.00** | **(32,350,326.29)** | **20,885,049.71** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | (4,777,796.00) | | (4,777,796.00) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 26,400,000.00 | | | 26,400,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 1,833,530,826.14 | 1,833,530,826.14 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **72,057,976.00** | **2,799,604.00** | **1,801,180,499.85** | **1,876,038,079.85** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **197,134,931.00** | **201,973,129.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **38,912,400.00** | **60,912,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 38,912,400.00 | 60,912,200.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 38,912,400.00 | 60,912,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 38,912,400.00 | 60,912,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **158,222,531.00** | **141,060,929.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,944,500.00 | 11,807,229.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,944,500.00 | 11,807,229.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 142,278,031.00 | 129,253,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 142,278,031.00 | 129,253,700.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **190,758,931.00** | **196,067,722.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **190,758,931.00** | **196,067,722.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **175,001,000.00** | **194,270,445.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 129,991,600.00 | 155,585,323.00 |
| 210101 | Үндсэн цалин | 119,004,291.10 | 140,343,523.00 |
| 210102 | Нэмэгдэл | 9,088,640.90 | 12,532,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,898,668.00 | 2,709,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,993,900.00 | 10,433,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,794,300.00 | 4,142,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,299,900.00 | 1,572,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,039,900.00 | 1,258,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 260,000.00 | 314,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,599,800.00 | 3,145,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | |
| 210302 | Түлш, халаалт | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,725,900.00 | 10,664,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,363,864.00 | 4,275,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,730,000.00 | 4,440,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,329,036.00 | 1,645,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 303,000.00 | 303,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 710,000.00 | 1,806,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210604 | Урсгал засвар | 710,000.00 | 1,806,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 2,695,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 2,695,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,006,900.00 | 2,683,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 675,600.00 | 716,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 333,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,691,300.00 | 1,433,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,572,700.00** | **10,401,822.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,472,700.00 | 9,401,822.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,100,000.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **15,757,931.00** | **1,797,277.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,174,231.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 6,174,231.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 9,583,700.00 | 1,797,277.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,583,700.00 | 1,797,277.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,376,000.00** | **5,905,407.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| 140001 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 140008 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,376,000.00** | **5,905,407.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,376,000.00** | **5,905,407.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,376,000.00 | 5,905,407.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,376,000.00 | 5,905,407.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(6,376,000.00)** | **(5,905,407.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 14 | **Бусад эх үүсвэр** | - | - |
| 145005 | Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх | | |
| 25 | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | - | - |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүү | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **190,165,900.00** | **188,368,623.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **190,165,900.00** | **188,368,623.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **190,165,900.00** | **188,368,623.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 157,286,500.00 | 155,585,323.00 |
| 210101 | Үндсэн цалин | 142,044,700.00 | 140,343,523.00 |
| 210102 | Нэмэгдэл | 12,532,800.00 | 12,532,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,709,000.00 | 2,709,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,433,700.00 | 10,433,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,142,200.00 | 4,142,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,572,900.00 | 1,572,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,258,300.00 | 1,258,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 314,600.00 | 314,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,145,700.00 | 3,145,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | |
| 210302 | Түлш, халаалт | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,664,600.00** | **10,664,600.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,275,700.00 | 4,275,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,440,200.00 | 4,440,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,645,700.00 | 1,645,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 303,000.00 | 303,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,306,700.00 | 5,306,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,806,700.00 | 1,806,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,695,300.00 | 2,695,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,695,300.00 | 2,695,300.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,779,100.00** | **2,683,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 716,700.00 | 716,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 333,300.00 | 333,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 70,800.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,433,300.00 | 1,433,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 190,165,900.00 | 188,368,623.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 129,253,700.00 | 127,456,423.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 129,253,700.00 | 127,456,423.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 60,912,200.00 | 60,912,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,912,200.00 | 60,912,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 12 | 12 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7 | 7 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **12** | **12** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 8 | 8 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4 | 4 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **15,944,500.00** | **11,807,229.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **15,944,500.00** | **11,807,229.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 15,944,500.00 | 11,807,229.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,944,500.00 | 11,807,229.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,944,500.00 | 11,807,229.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **15,944,500.00** | **11,807,229.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **15,944,500.00** | **11,807,229.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,944,500.00 | 11,807,229.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын  газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Орон нутгийн өмчийн газар нь Орон нутгийн өмчийн эзэмшил, ашиглалт, хадгалалт,  хамгаалалтыг сайжруулах, түүнд тавих хяналтыг өндөржүүлэх, бүртгэл тооцоог байгууллага бүрээр хөтлөн өмчийн үр ашгийг дээшлүүлэх, худалдан авах ажиллагааны шалгаруулалтыг ил тод, шударга болгож хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг хангаж ажилладаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант онд тус газар нь "Төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, мэргэшсэн, мэдлэг чадвар бүхий боловсон хүчнээр эгнээгээ бэхжүүлж, төрийн ёс зүйг чандлан сахиж, нутгийн иргэдийн эрх ашгийг дээдлэн төрийн үйлчилгээг шударга ил тод, шуурхай нээлттэй хүргэж ажиллана" гэсэн зорилтын дор ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ОНӨГ-т дотоод аудитор ажилладаггүй, тус газарт  2021 онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 194.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орон нутгийн өмчийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1859.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 808.4 | - | -808.4 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 640.50 | 1598.50 | 958.00 |
| Үндсэн хөрөнгө | 14,658.30 | 1,874,439.60 | 1,859,781.30 |
| **Нийт хөрөнгө** | **16,107.30** | **1,876,038.10** | **1,859,930.80** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 16,107.30 | 1,876,038.10 | 1,859,930.80 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **16,107.30** | **1,876,038.10** | **1,859,930.80** |

Мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлгүй, авлага дансны оны эхний үлдэгдлийг барагдуулж, оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.6 сая төгрөг болж 0.9 төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант онд 15.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 14.7 төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,891.6 сая төгрөг болж 1855.4 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2021 оны 112 дугаар тогтоолоор 2013 онд 3052.0 сая төгрөгийн өртгөөр баригдсан Битүү захын 60 хувь буюу 1831.5 сая төгрөгийн барилга, 26.4 сая төгрөгийн өртөгтэй 4400 м2 газрыг орон нутгийн өмчид бүртгэж, тус газрын данс бүртгэлд тусгасантай холбоотой хөрөнгийн дүн нэмэгдсэн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, 8.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг акталсан байна.

Өр төлбөр данс оны  эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл  1876.0 сая төгрөг болж 1859.9 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын оруулсан капитал 26.4 сая, тайлант үеийн үр дүн 1833.5 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2033.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1836.3 сая төгрөгөөр буюу  8 дахин өссөн  үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны орлого байна. Энэ нь хөрөнгийн санхүүжилтээр  хүлээн авсан хөрөнгийн дүн материаллаг хэмжээний өөрчлөлттэй  байгаатай холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 5.7 сая төгрөгөөр буюу  2.9  хувиар өссөн  байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, эд хогшил, томилолтын зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар 4.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт нь 2018 онд дахин үнэлгээний үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт нь тайлант онд акталсантай хөрөнгө холбоотой гарсан өөрчлөлтийн зөрүү байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2021 оны анх батлагдсан төсөв 190.2 сая төгрөг ба тодотгосон төсөв 190.2 сая төгрөг байна.

Тодотголоор анх баталсан төсвийг хэвээр нь баталж, дотоод албан томилолтын зардлаас 3.5 сая төгрөгийг багаж техник хэрэгсэл худалдан авах зардалд шилжүүлсэн байна.

Тус газар нь худалдан авах ажиллагааны шалгаруулалт хийх, тендер зохион байгуулахтай холбоотой тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах зорилгоор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүсэлт тавьж, батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж тодотголоор шилжүүлэн батлуулжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 190.2 сая төгрөгийн төсөв баталснаас 129.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 60.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 129.3 сая төгрөгийн, өөрийн орлогоос 60.9 сая төгрөг, нийт 190.2 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 188.4 сая төгрөгийг зарцуулж 1.8 мянган төгрөгийг орон төсөвт төвлөрүүлсэн байна.

Цалингийн зардлыг 1.7 сая төгрөгөөр,  БГАҮТ-ийн зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Цалингийн зардлын хэмнэлт нь аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор 13 орон

тоогоор баталсныг Сангийн яамнаас 12 орон тоогоор хянаж ирүүлсэнтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| № | Хөтөлбөр | Арга хэмжээ | Нэршил | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70426 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 190,165.9 | 188,368.6 | 1797.3 |
| 2 | | | | | | |
| **Нийт дүн** | | | | **190,165.9** | **188,368.6** | **1797.3** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус газар нь тайлант онд 60.9 төгрөгийн орлогын төлөвлөгөө өгөгдсөнөөс гүйцэтгэлээр 60.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 3.* Өөрийн орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,912.2 | 60,912.2 | 0.0 | 100.0 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | |
| **Нийт дүн** | **60,912.2** | **60,912.2** | **0.0** | **100.0** |

Үндсэн үйл ажиллагааны орлогыг түрээсийн орлого, цахим тендерийн хураамж, дуудлага худалдаа, хөрөнгө худалдсаны орлогоос бүрдүүлж, үйл ажиллагааны санхүүжилтээр зарцуулсан байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд цахим тендерийн орлогоос 9.4 сая, түрээсийн орлогоос 10.1 сая, барилга буулгасны орлогоос 13.8 сая, дуудлага худалдааны орлогоос 39.4 сая төгрөгийн нийт 72.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн үйл ажиллагааны санхүүжилтэд 60.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт орлогын санхүүжилтийг 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд 11.8 сая төгрөгийн санхүүжилтээс 7.4 сая төгрөгийг худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотой бараа үйлчилгээний урсгал зардалд, 4.4 сая төгрөгийн аймгийн Засаг даргын 2021 оны А/1097 тоот захирамжаар олгосон зөвшөөрлийн дагуу зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Орон нутгийн өмчийн газрын бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй. Битүү захын 1831.5 сая төгрөгийн барилга, 26.4 сая төгрөгийн өртөгтэй газрыг орон нутгийн өмчид бүртгэж, тус газрын данс бүртгэлд тусгасантай холбоотой нийт хөрөнгийн дүн өссөн байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орон нутгийн өмчийн газар нь нь 2021 онд нийт 4564.0 мянган төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4564.0 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, Шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг бүрэн байршуулах талаар зөвлөмж өгөгдсөн ба өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул гүйцэтгэлийн шалгалтаар төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх, шилэн дансанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроохгүй оруулж байхыг хянах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>